

Туслах гар, аврах гар

Далын Ахлагч Коичи Аояги

Бошиглогчийн зөвлөгөө, үлгэр жишээг дагаж, тусламж хэрэгтэй хүмүүсийг өдөр бүр эрж олцгооё.

Ах эгч нар аа, би энэ чуулган дээр үг хэлэх боломжтой байгаадаа маш их талархаж байна. Би Ерөнхийлөгч Томас С.Монсонд талархдаг бөгөөд тэр бол амьд Бурханы бошиглогч мөн гэдгийг гэрчилж байна. Гараа ашиглан, бусдад туслан, бусдыг аврахын төлөө амьдралаа зориулсан Ерөнхийлөгч Монсоны гайхамшигт үлгэр жишээ надад гүнзгий сэтгэгдэл төрүүлдэг юм.

Олон хүмүүс гай түйтгэртэй тулгаран, газар хөдлөлт, цунами, далайн шуурга, байгалийн бусад гамшгаас болж, гай зовлонд учирч байгаа цаг үед бид аж төрж байна. Хүмүүнлэгийн тусламжаар дамжуулан эдгээр хүмүүст туслахыг Сүмээс хичээж байна. Сүмийн гишүүд сар болгон итгэлтэйгээр мацаг барьж, өгөөмөр хандив өргөж, хайраар үйлчилдэг. Тэд үнэхээр Их Эзэний замаар тусламжийн гараа сунгадаг юм. “Ядуус хийгээд гачигдагсад, өвчтөнүүд хийгээд зовж шаналагсдыг бүх зүйлд санаж байгтун, учир нь үүнийг үл хийдэг тэрээр, мөнхүү тэр нь миний шавь биш бөлгөө” (С ба Г 52:40) гэсэн Их Эзэний зарлигийг тэд дагадаг.

Өнөөдөр би сүнслэг байдлын хувьд тусалж мөн авардаг гаруудын талаар голчлон яримаар байна. Их Эзэний ажил, алдар суу нь үнэхээр “үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралыг хүмүүнд тохиолгон авчрах” (Мосе 1:39) явдал билээ. Бидний эргэн тойрон дахь олон хүнд сүнслэг байдлын тусламж хэрэгтэй байдаг. Бид, идэвх султай гишүүд, гэр бүлээрээ бүгдээрээ сүмд явдаггүй гишүүд болон бидний адил итгэл бишрэлтэй биш хүмүүст авралын гараа сунгаснаар, бид тэднийг “Христэд ирэхийг” урьдаг.¹

Сүмд шинээр хөрвөгч байхдаа би, Сүмийн итгэлтэй нэгэн гишүүний авралын гараар сүнслэг байдлын хувьд аврагдсан юм. Би Японы Мацумото хотод өссөн бөгөөд энэ нь Нагоягийн өвлийн Олимп болсон газраас холгүй байдаг Миний

төрсөн хот Солт Лейк хот шиг, сайхан уулсаар хүрээлэгдсэн хөндийд байдаг. Би 17 настайдаа хоёр америк Ахлагч Картер, Ахлагч Хайаши хэмээх номлогчидтой танилцсан. Бид хоёр гуравхан насны зөрөөтэй байсан ч, ахлагч нарт миний урьд өмнө нь мэдэрч байгаагүй тийм нэгэн зүйл байсан. Тэд хичээнгүй, баяр баясгалантай, хайр энэрэл, гэрлээр дүүрэн хүмүүс байлаа. Тэдний зан чанар надад гүнзгий сэтгэгдэл төрүүлсэн болохоор би тэдэн шиг болохыг хүссэн юм. Би тэдний үгсийг сонсоод баптисм хийлгэхээр шийдсэн. Буддын шашинтай эцэг эх маань намайг баптисм хийлгэхийг эрс эсэргүүцэв. Гайхамшигтай нь, Их Эзэний болон номлогч нарын тусламжтайгаар би зөвшөөрөл авч, баптисм хийлгэв.

Дараа жил нь би Иокохама дахь их сургуульд орлоо. Төрсөн хот, таньдаг хүмүүсээсээ хол амьдарч байхдаа би ганцаардаж, Сүмээсээ холдов. Нэг өдөр би төрсөн хотынхоо Сүмийн нэгэн гишүүнээс ил захидал хүлээн авлаа. Тэрээр, намайг сүмийн цуглаанд оролцохоо больсон тухай сонссоноо бичээд, нэг судар эш татаж, намайг сүмд буцаж ирэхийг урьсан байлаа. Судрын тэдгээр үгс сэтгэл догдлом сайхан санагдаж билээ. Энэ нь ямар нэгэн чухал зүйлийг алдсанаа ухаарахад намайг хүргэсэн бөгөөд энэ тухай олон хоног тунгаан бодож, эргэцүүлж байлаа. Мөн түүнчлэн номлогч нарын өгсөн амлалтыг надад сануулсан юм. “Хэрвээ чи Мормоны номыг уншиж, Моронайн ном дахь амлалт үнэн үү гэж чин сэтгэлээсээ залбирч асуух юм бол, чи Ариун Сүнсний хүчээр үнэнийг мэдэх болно” гэж тэд амласан юм. ²

Би бүх зүрх сэтгэлээрээ залбирахгүй байсан юм байна гэдгээ ойлгоод, үнэхээр чин сэтгэлээсээ залбирч үзэхээр шийдэв. Нэг өглөө би эртлэн босоод, жижигхэн байрандаа өвдөг сөхрөн сууж, чин сэтгэлээсээ залбирсан юм. Яг л тэр амлалтын дагуу Ариун Сүнсний баталгаа над дээр цутган ирсэнд хэчнээн гайхсан гээч. Зүрх сэтгэл минь шатах лугаа адил болж, бие чичрэн, баяр хөөрөөр дүүрч билээ. Ариун Сүнсний хүчээр дамжуулан би Бурхан Эцэг, Түүний Хүү Есүс Христ хоёр амьд гэдгийг мөн тэд үнэхээр Иосеф Смит дээр хүрч ирснийг мэдсэн. Би наманчлан, амьдралынхаа эцсийг хүртэл Есүс Христийг итгэлтэйгээр дагах шийдвэрийг зүрх сэтгэлдээ гаргаж билээ.

Ийнхүү Сүнсийг мэдэрсэн нь амьдралыг минь бүрэн өөрчилсөн юм! Их Эзэнд болон намайг аварсан Сүмийн тэр нэгэн гишүүнд баярлан талархнаас үүдэн би номлолд үйлчлэхээр шийдэв. Номлолынхоо дараа, би ариун сүмд нэгэн гайхамшигт бүсгүйтэй гэрлэж, лацдан холбуулсан бөгөөд бид хоёр 4 хүүхдээр адислагдсан билээ. Тэр охин бол олон жилийн өмнө Иокохамад ганцаардан гуниглаж суусан залууд ил захидал илгээж намайг аварсан нөгөөх охин байсан нь тохиолдлын хэрэг биш шүү дээ.

Дууллын номонд, “Би төөрсөн хонь шиг замаас гажин явсан билээ. Өөрийн зарцыг хайн олооч. Учир нь би Таны тушаалуудыг мартдаггүй билээ” (Дуулал 119:176) гэж бичсэн байдаг. Би Их Эзэний нигүүлсэл, намайг дахин “Христэд ир” хэмээн урьсан Сүмийн энэ гишүүний тусламжинд үүрд талархаж явах болно.³

Та нараас олон нь өдөр бүр хайрын болон авралын гараа сунгаж байдгийг би мэднэ. Айлчлан очдог эгч нараа төдийгүй, өвчтэй эсвэл тусламж хэрэгтэй байгаа ямар ч эгчийг халамжилж, хайрын гараа үргэлж сунгадаг Нийгмийн Халамжийн нэгэн эгчийг би мэднэ. Тойргийнхоо бэлэвсэн хүмүүсийнд үе үе зочилдог байсан нэг бишопыг би мэднэ. Тэр чөлөөлөгдсөнийхөө дараа олон жил нөгөө бэлэвсэн хүмүүстэй уулзаж, жаргал зовлонг нь хуваалцдаг байлаа.

Эцгээ алдсан нэгэн залуу эрэгтэйд цаг заваа харамгүй зориулдаг санваартны нэг удирдагчийг би мэднэ. Тэрээр түүний үйл ажиллагаанд нь оролцож, сайн мэдээг заан, өөрийнх нь эцгээс ялгаагүй түүнд зөвлөгөө өгдөг. Өөр нэгэн гэр бүл түүнтэй сайн мэдээг хуваалцсанаар баяр хөөрийг олдог. Эцэг эх хүүхдүүд өөрсдийн эргэн тойрон дахь хүмүүст сайн мэдээний талаар гэрчилдэг бөгөөд олон хүмүүс тэднийг хайрладаг.

Хүүхдийн Хэсгийн үйл ажиллагааны нэг хэсэг болгож, манай таван настай зээ охин сайн үйлсийг хийх болгондоо том шилэн саванд эрдэнэ шишийн үрийг хийдэг. Тэрээр өдөр бүр хийх сайн үйлсийг хайж Хүүхдийн Хэсгийн дараах дууг чангаар дуулдаг, “Бошиглогчийг дага, бошиглогчийг дага, бошиглогчийг дага, тэр замыг мэднэ!”⁴

Сүмийн гишүүдийн хийж байгаа бүх сайн үйлсийн талаар та нарт ярих хангалттай цаг надад алга. Тэд үүрэг хариуцлагаараа биш, харин өөрсдийн хүслээр, баяр хөөртэйгээр, чимээгүйгээр бошиглогчийн зөвлөгөөг дагадаг.

Заримдаа бид өөрсдийгөө сул дорой гэж бодон бусдыг аврах хүчээр дутагдаж байгаа юм шиг санадаг. Гэхдээ Их Эзэн “Үнэнээр би та нарт хэлье. Та нар эдгээр ах дүүсийн маань нэгэнд нь, тэр байтугай хамгийн дордод нь тийнхүү хандсан бол Надад хийсэн хэрэг” (Матай 25:40) хэмээн бидэнд сануулдаг билээ.

Ерөнхийлөгч Томас С.Монсоны хэлсэн үгсээр би үгээ өндөрлөө: “Ах эгч нар аа, бидний анхаарал халамж, урам дэм, туслалцаа, тайтгаруулал, нинжин сэтгэл хэрэгтэй байгаа хамаатан садан, найз нөхөд, таньдаг таньдаггүй хүмүүс бидний эргэн тойронд хаа сайгүй байна. Бид бол дэлхий дээрх Түүний хүүхдүүдэд үйлчилж, тэднийг өргөх үүрэгтэй Их Эзэний гар болсон хүмүүс юм. Тэрээр бидний хүн нэг бүрд найдлага тавьдаг”.⁵

Бид Их Эзэний хүүхдүүдэд туслан, тэднийг аврах гар нь болж, бошиглогчийн зөвлөгөө, үлгэр жишээг дагаж, тусламж хэрэгтэй хүмүүсийг өдөр бүр эрж, олж байхын төлөө би Есүс Христийн нэрээр залбирч байна, амен.

ТЭМДЭГЛЭЛ

1. Номлолын ажлын удирдамж: Миний Сайн мэдээг номло (2004) 1, гарын авлагыг үз,
2. Моронай 10:4-5-ыг үз.
3. Матай 11:28-ыг үз.
4. “Follow the Prophet,” *Children's Songbook* 1989, 110--11.

5. Томас С.Монсон, “What Have I Done for Someone Today?” Лиакона, 2009 оны 11 сар, 86.